



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/653

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 45.7 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 278, 2024 оны 265 дугаар тогтоол, “Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол төслийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Д.Батцэцэг)-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2.Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 1,107,744,100,000.0 (нэг их наяд нэг зуун долоон тэрбум долоон зуун дөчин дөрвөн сая нэг зуун мянга) төгрөгийн 754,013,330,000.0 (долоон зуун тавин дөрвөн тэрбум арван гурван сая гурван зуун гучин мянга) төгрөгийг “Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “4”-д заасан “Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол”-ын хөрөнгөөс, 353,730,770,000.0 (гурван зуун тавин гурван тэрбум долоон зуун гучин сая долоон зуун далан мянга) төгрөгийг “Сэлбэ дэд төвийн борлуулалтын орлого”-оос холбогдох хууль, журмын дагуу тухай бүрт эх үүсвэрийн хэмжээгээр гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, “Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК (У.Баатар)-т тус тус даалгасугай.

3.Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тавьж ажиллахыг “Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК (У.Баатар)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал

1725023133

хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/571 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
 05 дугаар сарын 07-ны өдрийн
 17.05.27 дугаар захирамжийн
 хавсралт

СЭЛБЭ ДЭД ТӨВИЙН ОРОН СУУЦНЫ ИЖ БҮРЭН ЦОГЦОЛБОР ХОРООЛОЛ
 ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн	
		Эхлэх	Дуусах		Нийслэлийн төсвийн хөрөнгө	Сэлбэ дэд төвийн борлуулалтын орлого
1	Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол БАГЦ-3	2025	2025	616,599.10	431,619.40	184,979.70
2	Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол БАГЦ-4	2025	2025	491,145.00	322,393.93	168,751.07
НИЙТ ДҮН				1,107,744.1	754,013.33	353,730.77